

Тэргүүн байрын бүтээл:

## “ХАРИУЦЛАГАТАЙ ХАРИЛЦАГЧ – ХАРИУЦЛАГАТАЙ БАНК”

Оролцогч:

Ч.Хонгорзул, нягтлан бодогч

Банк нь санхүүгийн зуучлагчийн хувиар эдийн засаг дахь баялгийг дахин хуваарилж, тухайн улсын хөгжлийг дэмжиж байдаг чухал агент юм. Ялангуяа хөгжиж буй эдийн засагтай Монгол Улс шиг орнуудын хувьд санхүүгийн зах зээлийн хөгжил сул, банкны салбарт төвлөрөл өндөр байдаг. Олон Улсын санхүүгийн хямрал 2008 онд тохиолдсоноос хойш дэлхий даяар өндөр ашигтай банкуудыг дэмжихээс илүүтэй хариуцлагатай (responsible), тогтвортой (sustainable), ёс зүйтэй (ethical) банкуудыг сурталчлах болжээ. Энэхүү нийтлэлийг банкны хариуцлага, нөгөө талаас харилцагчдын хариуцлагын талаар уншигчдад ойлголт өгөх, хамтдаа хариуцлагатай байхыг уриалах зорилгоор бичлээ.

Хариуцлагатай банк нийгэмд гүйцэтгэх үүргийг тодорхойлохын өмнө хариуцлагатай банк гэж ямар банкныг хэлэх, банкууд яагаад хариуцлагатай байх ёстой талаар ойлголт өгөхийг хичээе. Монгол хэлний тайлбар толь бичигт хариуцлагатай гэж эрхэлсэн болон даалгасан ажил үүргийг сайн биелүүлдэг гэсэн утгыг илэрхийлэх бол банк гэдэг нь бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох ашгийн төлөө хуулийн этгээд юм<sup>1</sup>. Тэгвэл үгийн тайлбар талаас хариуцлагатай банк нь ашгийн төлөө эрхэлсэн үүрэг даалгавраа сайн биелүүлдэг хуулийн этгээд болно. Энэхүү тодорхойлолтыг өргөтгөвөл **хариуцлагатай банк** гэж өөрийн ашгийг нэмэгдүүлэхийн сацуу нийгмийн сайн сайхныг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг эдийн засгийн агент юм.

Итгэлцэлд суурилсан томоохон агентын хувьд хариуцлагатай банк нийгэмд ямархуу эерэг дам нөлөө үүсгэх нь тодорхой. Тухайлбал, нийт хөрөнгийн хэмжээгээр Бразил Улсдаа хоёрт орох хувийн банк болох Банк Итау-Бба<sup>2</sup> (Banco Itau-Bba) нь олгож буй зээлийн хүрээлэн буй орчин, нийгэмд учруулах эрсдэлийг

<sup>1</sup> “Банкны тухай” хууль, 3.1.1 дүгээр заалт

<sup>2</sup> [www.itaubba.com.br](http://www.itaubba.com.br)

тооцоолж эхэлсэн анхны Бразил банк болжээ. Тус банк олон улсын байгаль орчны зөвлөгч компаниас туслалцаа аван, зээлийн үнэлгээндээ байгаль орчны эрсдэлийг тусгасан байна. Түүнчлэн 2000-2006 оны хооронд Бразилын хөгжлийн банктай хамтран 1.8 тэрбум долларын санг нийгмийн сайн сайханд тустай дэд бүтэц, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зарцуулж, санхүүжилт олгожээ. Бразил Улсын жишээнээс үзэхэд банк нийгмийн сайн сайханд чиглэсэн үйлдлээрээ асар эерэг дам нөлөөтэй байдаг. **Ялангуяа, зөвхөн эдийн засгийн өсөлт бус хөгжлийг бий болгохыг зорьж буй өнөө үед хариуцлагатай банк байх нь эдийн засгийн бусад агентад асар ач холбогдолтой юм.** Энэтхэгийн төв банкны ерөнхийлөгч П.Вижаяя Баскар хөгжиж буй орнуудын хувьд хариуцлагатай банкны тухай асуудал зайлшгүй хөндөгдөх нь зүйн хэрэг бөгөөд тэдний үйл ажиллагаа хүний эрх, хүрээлэн буй орчныг сайжруулахад чиглэгдсэн байх талаар дурдаж байв.

Банк хариуцлагатай байх нь тухайн банканд ашигтай юу?. Хариуцлагатай байснаар банкны олох хамгийн том давуу тал нь олон нийттэй харилцах харилцааг нэмэгдүүлж, нийгмийн сайн сайханд чиглэсэн үйлдлээр ашгаа нэмэгдүүлэх боломжтой болох юм. Түүнчлэн нэг банкны хариуцлагагүй үйлдэл санхүүгийн систем, цаашлаад олон сая хүний амьдралд сөргөөр нөлөөлснийг 2008 оны санхүүгийн хямралаас харах боломжтой. Монгол Улс шиг банкны салбар нийт санхүүгийн салбарын 95 орчим хувийг бүрдүүлдэг, жижиг зах зээлд нэг банкны хариуцлагагүй үйлдэл системд хүчтэй нөлөөлж болно. Иймд банк хариуцлагатай байснаар системийн эрсдэлийг бууруулаад зогсохгүй, нийгэмд эерэг дам нөлөөг үүсгэх, үүсгэсэн чиг хандлагаараа хэрэглэгчдийг татах боломжтой.

Банк хариуцлагатай байхын тулд ямар үйл ажиллагаа эрхлэх шаардлагатай вэ? UNEPFI олон улсын байгууллагаас хариуцлагатай банкуудын зарчмыг тодорхойлон гаргадаг. Эдгээр зарчим нь үндсэндээ:

- Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн үйл ажиллагаа явуулах;
- Мэдээллээ ил тод, ойлгомжтой, шударгаар олон нийтэд мэдээлэх;
- Харилцагчдын эрх ашгийг хамгаалах;
- Дотоод үйл ажиллагааг байгальд ээлтэй, нийгмийн сайн сайханд чиглэсэн байдлаар эрхлэх талаар тусгасан байдаг.

Macdonald & Rundle-Thiele (2008) нарын судалгаанаас банкууд нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа биелүүлэхдээ харилцагчдад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэйг тогтоосон байна. Иймд банк харилцагчдаа хүндэлж, мэдээллээ ил тод, шударгаар олон нийтэд мэдээлэх нь хариуцлагатай банкны баримтлах хамгийн эхний зарчим юм. Харилцагчид рационал гэж үзвэл банкны хангаж буй хадгаламж эсвэл зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэлд үндэслэн оновчтой шийдвэр гаргахыг зорьдог. **Иймд банк харилцагчдыг тэгш бус мэдээллээр хангаж, шийдвэр гаргалтад нөлөөлөх бол хариуцлагатай банк байх хамгийн энгийн дүрмийг зөрчиж байгаагийн шинж болно.** Нөгөө талаас банкны эрхлэх эдгээр үйл ажиллагаа нь хоорондоо уялдаа холбоотой байх ёстой. Тухайлбал, банк байгальд ээлтэй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх боловч ажлын байранд шаардлагагүй ус, эрчим хүч, цаас ашиглах эсвэл харилцагчдын эрх ашгийг хүндлэх олон зарчмыг баримтлах боловч мэдээллээ нуун дарагдуулах, худал мэдээллээр харилцагчдыг хангах үйлдэл нь банкны үйл ажиллагаанд нийцгүй байдлыг үүсгэх юм.

Нөгөө талаас, шувуу зөвхөн нэг далавчаа ашиглах нь шувууны биед тэнцвэргүй байдал үүсгээд зогсохгүй шувууг нисэх боломжгүй болгохтой адил банк хариуцлагатай болж байхад харилцагчид хариуцлагагүй бол санхүүгийн зах зээл хөгжих үү?. Сүүлийн жилүүдэд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал 2018 оны нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 10.4%, хугацаа хэтэрсэн зээл 4.9% байв. Иймд банкууд хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг эрсдэлд оруулахаас зайлсхийх зорилгоор хэт өндөр ашигтай гэхээс илүүтэй эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийж байна. Банкны салбар нь итгэлцэлд суурилдаг тул банк нь харилцагчдын хөрөнгийг барьцаагүйгээр, хадгаламж хэлбэрээр авч цаашлаад бусад агентуудад зээл олгодог. Хэдийгээр мөнгөний үржүүлэгчийн нөлөөгөөр банк мөнгийг бүтээдэг гэх боловч зээлдэгчдийн авч буй зээл оргүй хоосноос гарч ирдэггүйг харилцагчид ойлгох хэрэгтэй. Банк нь хэн нэгний хөрөнгийг тодорхой хугацаанд өсгөх амлалт өгсний үндсэн дээр өөр нэгэнд тухайн хөрөнгийг зуучилж байгаа юм. Иймд зээлдэгчдийн хүлээн авч буй зээл нь өөр хэн нэгний хөрөнгө байдаг.

Зарим зээлдэгчид үүнийг ойлгохгүйн улмаас зээлээ төлөхгүй байх хандлага ажиглагдаж байгаа нь харамсалтай. Жишээ нь Монгол Улсын томоохон банкны тусгай активын мэргэжилтэн буюу тун энгийнээр зээл төлүүлэх мэргэжилтэн нэгний туршлагаас үзэхэд зарим харилцагчид хүлээн авсан зээлээ төлөх огтхон ч сонирхолгүй байдаг бөгөөд маш их эрэл, хайгуулын дүнд төлүүлэх үйл ажиллагаа хийгддэг ажээ. Хэдийгээр банк зээл олгохын өмнө зээлийн скорингийн аргаар зээлдэгчдийг үнэлдэг боловч харилцагчдын зүгээс тэгш бус мэдээлэлд үндэслэн ёс суртахууны гажуудал үүсгэх хариуцлагагүй хандлага үргэлжилсээр байвал систем нурж унадаг. Үүний жишээ нь ч мөн саяхан Монголын нэг банкыг татан буулгасан явдлаар илэрч байна.

Бангладеш улсын Гриймэн банк нь нийгмийн эмзэг, ядуу ангилалд багтах эмэгтэйчүүдэд барьцаагүй зээл олгож, нийгмийн сайн сайханд чиглэсэн төсөлд хөтөлбөрийг санхүүжүүлснээрээ Нобелийн шагнал хүртсэн байдаг. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн бодлогыг дэмжсэн хариуцлагатай харилцагч байх хүсэл нь тус банкиг хамгийн өндөр зээлийн эргэн төлөлттэй банк байх боломжийг олгодог ажээ. Энэхүү жишээ нь хариуцлагатай харилцагч эдийн засагт ямар эерэг дам нөлөөтэйг мөн харуулж байна. Хариуцлагатай харилцагч байхын тулд банкны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь маш чухал юм. Банктай харьцуулахад нэгж харилцагч нийгэмд үзүүлэх нөлөө нь харьцангуй бага боловч харилцагч бүрийн үйлдэл банкны үйл ажиллагаанд нөлөөлдөг. Иймд банкнаас өгч буй мэдээлэлтэй харилцагч сайтар танилцаж, гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ биелүүлэх боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийх нь чухал.

Монгол Улс хоёр шатлалт банкны систем рүү шилжээд 30 гарам жил өнгөрчээ. Энэ хугацаанд банкны салбар цөөнгүй хэмжээний сорилтуудтай тулгарч, шинэчлэлийг хийн, өдөр бүр хөгжсөөр байна. Тухайлбал, банкуудын нийт актив 2010 онд ДНБ-ий 60.2 хувьтай тэнцэж байсан бол 2018 онд 92.2 хувь болж, 32 нэгж хувиар өссөн нь банкны салбарын хурдацтай өсөлтийг харуулж байгаа юм. Цаашид сорилтуудыг амжилттай давах арга зам нь хариуцлагатай банк болон хариуцлагатай харилцагч байх явдал болно. Дэлхий нийтээр хариуцлагатай санхүүгийн системд шилжиж буй өнөөгийн үед Монгол Улсад харилцагчид

хариуцлагажих үүнийг дагаад банкууд хариуцлагажих шаардлага өндөр байна. Хариуцлагатай банкны системтэй тохиолдолд хэлцэлд оролцогчид нэгэндээ тавих хяналт өндөр байх, цаашлаад санхүүгийн систем эрүүлжих хандлагатай болох юм. Иймд банк гэлтгүй харилцагчид хүлээсэн үүрэгтэй хариуцлагатай хандацгаая.

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

- International Finance Corporation. (2007). *Banking on Sustainability: Financing Environmental and Social Opportunities in Emerging Markets*. Pennsylvania.
- Khan, A. I. (2016). Microcredit and Grameen Bank: A View From the Grassroots. *International Journal of Current Research*, 41387-41395.
- Lenka, B., & Jiří, P. (2014). Corporate Social Responsibility in Commercial Banking - A Case Study from the Czech Republic. *Journal of Competitiveness*, 50-70.
- McDonald, L., & Rundle-Thiele, S. (2008). Corporate Social Responsibility a Bank Customer Satisfaction. *International Journal of Bank Marketing*, 170-182.
- Responsible Banking: Working Paper 1. (2016, August). *Why be responsible? The case for being a good bank*, pp. 1-12.
- Soana, M.-G. (2011). The Relationship Between Corporate Social Performance and Corporate Financial Performance in the Banking Sector. *Journal of Business Ethics*, 133-148.
- UNEP Finance Initiative. (2018). *Principles for Responsible Banking*. Switzerland.